





Тайлагнах хугацаа		2023 оны 01 дүгээр сарын 01 нээс 2023 оны 12 дугаар сарын 31
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Ремикон ХК 9010001071 RMC 7777-7704 Гаули ҮЦК
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Барилгын материал үйлдвэрлэл
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Шонхор үнэлгээ аудит ХХК,
Жилийн эцсийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-д бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		78679464
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо		Ремикон ХК Ерөнхий нягтлан бодогч Э.Эрдэнэцэцэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		
1 Жилийн санхүүгийн тайлан		
Санхүүгийн байдлын үзүүлэлт		Гийг хөрөнгийн дүн 31,501,507,141.62 гийг өр төлбөр 0в эсдийн өмч 31,501,507,141.62
Орлогын тайлан		Борлуулалтын орлого 30,745,392,838.10 Татвар төлөхийн өмнөх ашиг 4,465,923,251.13
Өмчийн өөрчлөлтийн тайлан		Өмч ашиг алдагдалын дүнгээр өсөөд өмчийн дүн 15,440,519,305.60
Мөнгөн гүйлгээний тайлан		Бүх цэвэр мөнгөн орлогын дүн 15,745,447,918.48
1.1 Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт		
Аудитын ажил хийгдэж байгаа		
1.2 Аудитын тодорхойлох захидал		
Цаасаар хавсаргав		
2 Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, үндснээр өсөж өсөх үнэлгээ, цаашид авч		
2.1 Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/		Цаасаар хавсаргав
2.2 Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт		Цаасаар хавсаргав
2.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл		Цаасаар хавсаргав
2.4 Гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/		Санхүүгийн тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй
2.5 Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;		Худалдаа хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор 1800,000,000 төгрөгийн зээлийг 2022.12 сард авсан. Уг зээлд эргэн төлөлт 200,000,000 хийгдээд мөнгөн үрсгал хүрэлүүхгүй нөхцөлөөс болоод зээл хойшлуулах хүсэлт тавиад 2024.01 сард зээлийн гэрээш шинэчилсэн. 2024 оны 08-12 сард эргэн төлөлтийн хуваарьтай
3 Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, Сонирхлын зөрчилтэй хэлцэл, ажил гүйлгээ байхгүй		
4 Цалин урамшууллын мэдээлэл		
2023 онд цалин урамшуулалд 1,608,249,741.91 төгрөг олгосон байна. Үүнээс ТУЗ болон хараат бус гишүүдэд 5400,000 цалин хөлс олгосон		
5 Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл		
Цаасаар хавсаргав		
6 Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл		
1. Барилгын салбар дахь орон сууцны үнийн хөөрөгдөлөөс нөлөөтэй салбар уналтаас үүдэн авлага төлөгдөхгүй бэлэн мөнгө эргэлдэхгүй байгаа нь буцаад түүхий эд материал татах, эргэлтийн хөрөнгөгүйдэх эрсдэл үүсгэж байна.		
7 Хувьцаа эзэмшил үүдлийн мэдээлэл		
Хувьцаа эзэмшигчийн нэр		Хувьцааны тоо
1. Хассуурь Ганхуяг		
2. Imperia Mongolia Holding LTD		35,352,294.00
3. Хера холдинг ХХК		10,115,617.00
4. Фронтнер ХХК		5,310,344.00
5. Lee Jung Suk		4,905,909.00
		3,505,900.00
8 Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгосон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл		
Төслийн зорилгоор нийтэд зориулж хувьцаа гаргаггүй		
9 Ногдол ашгийн мэдээлэл		
20223 оны санхүүгийн тайлангаар ашигтай гарсан хэдий ч ногдол ашиг тараах нь компанийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж байгаа тул компанийн дүрмийн 6-р зүйлийг үндэслэн ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн.		
10 Үнэт цаас гаргачаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажил тайлангийн мэдээлэл		
1. Ажилчидаа болон тэдгээрийн арг гэрт нэг удаагийн тэтгэмж байлдлаар мөнгөн дүнгээр 63,420,048.18 төгрөгийн үйл ажиллагааны бус зардал гаргасан байна.		
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийг үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Э.Мөнхсайхан		Овог, нэр: Д.Шийрэв
Албан тушаал: "Ремикон" ХК -ийн Гүйцэтгэх захирал		Албан тушаал: "Шонхор үнэлгээ аудит" ХХК -ийн Захирал
Гарын үсэг: 		Гарын үсэг: 
		
Мэдээлэл балтгаж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Э.Эрдэнэцэцэг		
Албан тушаал: "Ремикон" ХК -ийн Ерөнхий нягтлан бодогч		
Гарын үсэг:		

1. Төлбөрийн чадварын шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2022 он	2023 он
Төлбөрийн чадварын шинжилгээ	Цэвэр эргэлтийн хөрөнгө	10,245,414,956	14,096,565,700
	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	2.0	1.8
	Түргэн хөрвөх хөрөнгө	14,075,398,218	19,428,346,085
	Эргэлтийн харьцаа	2.4	2.3
	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.71	0.78
	Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.59	0.56
	Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин	0.42	0.33

Төлбөрийн чадварын шинжилгээнээс харахад Ремикон ХК нь 2022 оноос 2023 онд илүү сайн үзүүлэлттэй байна.

Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 3.8 тэрбумаар нэмэгдсэн бөгөөд энэ нь борлуулалт нэмэгдэж өр төлбөр буурсны илрэл юм.

Эргэлтийг харьцааг харахад 1.8 байгаа нь 1 төгрөгийн өр төлбөрт 1.8 төгрөгийн эргэлтийн хөрөнгө ноогдож байгааг харуулж байна. Энэ харьцаа нь 2той ойр байвал илүү сайн гэж үздэг. Учир нь 1 төгрөгийн өр төлбөрийг эргэлтийн хөрөнгө нь нугалж байх тусам компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Мөн төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жинг харахад 2023 онд өмнөх оноос буурсан бөгөөд энэ үзүүлэлт нь буурч байвал сайн гэж үздэг. Учир нь өр төлбөр буурч байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж төлөх дүнг бууруулж байгаа. Ингэснээрээ компанид өр төлбөр буурах нь эргэлтийн хөрөнгөд эерэг нөлөөтэй.

2. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2022 он	2023 он
Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ	Бие даах чадварын коэффициент	0.50	0.50
	Санхүүгийн хамаарлын коэффициент	2.02	2.05
	Зохицуулалтын коэффициент	0.84	0.90
	Өөрийн эргэлтийн хөрөнгө	10,245,414,956	14,096,565,700
	Өр төлбөрийн хувийн жин	0.50	0.51
	Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа	0.43	0.35
	Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	1.02	1.05

Бие даах чадварын коэффициент нь 0,6 болон түүнээс дээш байх нь сайн үзүүлэлт болно. Энэ нь гадны эх үүсвэрээс хараат бусаар өөрийн санхүүжилтээр бие дааж үйл ажиллагаа явуулах чадварыг харуулна. Компанийн хувьд одоогийн нөхцөлд өөрийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулах нөөц боломж чадвар нь боломжийн байгаа юм.

Харин өр төлбөрийн хувийн жингийн үзүүлэлтээс харахад 1 төгрөгийн өр төлбөрт ноогдох эзний өмч нь 0,51 төгрөг байгаа нь өр төлбөр буурч байгаагийн илрэл юм. Ингэснээр компанийн хувьд урт болон богино хугацааны хөрөнгө оруулалтын шугамаар зээл авах боломж байгааг харуулж байна.

3. Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд

Санхүүгийн харьцаа		2022 он	2023 он
Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд	хүү төлөх чадвар	7.33	8.1
	Хүү ба үндсэн өрийг төлөх чадвар	1.19	2.1

Хүү төлөх чадварын коэффициент нь нэг төгрөгийн хүүг төлөх татварын өмнөх ашгийн хэмжээг харуулдаг. Энэ үзүүлэлт нь нэгтэй тэнцүү байхад болно гэж үздэг. Харин компанийн хувьд 8.1 төгрөг байгаа нь зээлийн хүүг төлөх чадвартайг нотолж байна.

4. Эргэцийн шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2022 он	2023 он
	Авлагын эргэц /удаа/	1.84	1.64
	Авлагын эргэц /өдөр/	195	219
	Бараа материалын эргэц /удаа/	8	8
	Бараа материалын эргэц /өдөр/	47	46
	Эргэлтийн хөрөнгийн эргэц /удаа/	1.42	1.23
Эргэцийн шинжилгээ	Эргэлтийн хөрөнгийн эргэц /өдөр/	254	293
	Нийт хөрөнгийн эргэц	1.01	0.96
	Өглөгийн эргэц /удаа/	0.53	0.39
	Өглөгийн эргэц /өдөр/	677.79	926.43
	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа	242	265
	Санхүүгийн циклийн хугацаа	(436)	(661)

Эргэцийн шинжилгээнээс харахад манай компанийн өр болон авлагын эргэц удаан харагдаж байна. Өөрөөр хэлбэл авлага 195 хоногтоо эргэж орж ирж байна. Бараа материал 46 хоногт, эргэлтийн хөрөнгө 293 өдөрт, өглөг 926 өдөрт эргэж байна.

5. Бүтээмжийн шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2022 он	2023 он
Бүтээмжийн шинжилгээ	Хөдөлмөрийн бүтээмж	426,697,076	530,092,980
	Үндсэн хөрөнгийн ачаалал	4.70	6.14
	Материал өгөөмж	10.56	10.83
	Үндсэн хөрөнгийн хувийн жин	0.21	0.16
	ҮХ-ийн нийт дүнд үйлдвэрлэлийн зориулалттай ҮХ-ийн эзлэх хувийн жин	0.8	0.8
	ҮХ-ийн элэгдлийн коэффициент	0.12	0.07

Бүтээмжийн шинжилгээнээс харахад ажилчдын хөдөлмөрийн бүтээмж өндөр байна гэж харагдаж байна. Өөрөөр хэлбэл компанийн нэг ажилчин 530 сая төгрөгийн бүтээгдэхүүн бүтээж байна.

Мөн үндсэн хөрөнгийн ачаалал сайн байгаа бөгөөд нэг төгрөгийн үндсэн хөрөнгө 6.1 төгрөгийн орлогыг бүтээж байна. Дараагийн нэг үзүүлэлт нь нэг төгрөгийн материалаар 10.83 төгрөгийн орлого олж байна.

6. Ашигт ажиллагааны шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2022 он	2023 он
Ашигт ажиллагааны шинжилгээ	Борлуулалтын ашигт ажиллагаа	0.27	0.28
	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	0.37	0.39
	Хөрөнгийн ашигт ажиллагаа	0.11	0.13
	Эздийн өмчийн ашигт ажиллагаа	0.22	0.26

Ашигт ажиллагааны шинжилгээнээс харахад нэг төгрөгийн борлуулалтаас 0.28 төгрөгийн ашиг олж байна. Өөрөөр хэлбэл нэгж бүтээгдэхүүнээс 28%-ийн нийт ашиг олж байна гэсэн үг.

Хөрөнгийн ашигт ажиллагааг харахад нэг төгрөгийн хөрөнгөөр 0.13 төгрөгийн ашиг бүтээж байна. Мөн эздийн өмчийн ашигт ажиллагааг харахад нэг төгрөгийн эзний өмчөөр 0.26 төгрөгийн ашиг авч ирж байна.

7. Зах зээлийн идэвхижлийн шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2022 он	2023 он
Зах зээлийн идэвхижлийн шинжилгээ	Зах зээлийн үнэ ба ашгийн харьцаа	0.69	0.46
	Зах зээлийн үнэ ба бүртгэлийн үнийн харьцаа	0.24	0.24
	Нэгж хувьцааны бүртгэлийн үнэ	100	100

Зах зээлийн үнэ ба ашгийн харьцаа нь хувьцааны үнэ цэнийн өсөлтийг харуулах үзүүлэлт юм. Манай компанийн хувьд хувьцааны анхны үнэ 100 төгрөг байсан бол одоо 35 төгрөг болж унасан байна. Эндээс харахад компанийн хувьд салбарын байдлаас шалтгаалж ашигт ажиллагаа муудсан, урт хугацаат өр төлбөртэй удсанаас зээлжих чадамж буурсан, дээрхи нөхцөл байдал нь удаан жил үргэлжилсэн тул ханш унаж тогтмол доогуур байлаа.



“РЕМИКОН” ХХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088

Цахим хаяг: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2024.01.30 № 24/11

танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрээт ажлын захидал

Таны энэ өдрийн амар амгаланг айлтгая

“РЕМИКОН” ХХК-ийн 2023.12.31-нээрх тасалбар болгосон санхүүгийн зэрэгцүүлсэн мэдээлэлд аудит хийлгэх тухай хүсэлтийг хүлээн авч байгаагаа илэрхийлэн, дор дурдсан зарчмын зүйлүүдийг энэхүү захидлаар Та бүхний сонорт хүргэхийг хүсч байна.

Энэхүү гэрээт ажил нь юуны өмнө танай компанийн 2023.12.31-нээрх тасалбар болгосон санхүүгийн тайланг Монгол улсын хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу шалгаж, үнэлэх зорилготой. Бид гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнд үндэслэн танай санхүүгийн тайлангийн талаар аудиторын тайлан, дүгнэлт гаргах буюу мэргэжлийн саналаа илэрхийлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудын зарчмуудад нийцүүлэн бэлтгэж танилцуулах нь танай байгууллагын удирдлагын хүлээх үүрэг хариуцлага болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг сонгож хэрэглэх, эдгээрийн үр дүнг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд шударгаар толилуулах зэрэг үүргүүд багтана.

Өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж, үр нөлөө бүхий нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг хууль стандартын дагуу тогтмол үр дүнтэй ажиллуулах нь удирдлагын хууль ёсны үүрэг байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитыг Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбоо /IFAC/-ны Аудит Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/-ын дагуу гүйцэтгэнэ. Энэ стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг алдаа ба буруу тайлагналаас ангид илэрхийлэгдсэн эсэх талаар дунд түвшний баталгаа гаргах чиглэл удирдамж болдог. Аудитыг байгууллагын ажилтнуудаас асуулга тавьж харилцан ярилцах, санхүүгийн тайлан дахь тоон мэдээллүүдэд тулгуурласан шинжилгээ судалгаа харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх, давтан гүйцэтгэх, хөөн шалгах болон аудитын сорил горимуудаар хэрэгжүүлдэг.

Бид гэрээт ажлаа Аудитын тухай хуулийн зарчимд нийцүүлэн урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхэд баримталсан зарчим сонгож хэрэглэсэн аргыг бүхэлд нь үнэлнэ. Удирдлагын шийдвэр үлэмж хэмжээний дүн бүхий тооцоолол онцлог үйл явдлуудын бүртгэл ба үйл явдлуудыг тусгайлан авч үзнэ.

Санхүүгийн тайлан ба нэмэлт тодруулгад тусгагдсан мэдээллийн талаар нотлох зүйл олж авахын тулд түүврийн болон бусад сорил горимуудыг ашиглана. Аудитын ажлын үр дүнд танай байгууллагын 2023.12.31-нээрх үлдэгдлийн тэнцэл, орлого, үр дүн болон мөнгөн гүйлгээ нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн талаарх Монгол улсын хууль тогтоомж, Сангийн яамнаас баталж мөрдүүлсэн заавар аргачлалын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн эсэхийг тодруулан тайлагнах болно. Та бүхнээс бэлтгэж толилуулсан санхүүгийн тайланд хийсэн аудитын ажлын тайлангийн бодит байдал нь бидний хүлээх хариуцлага болно.

Аудитын ажлын онцлог, үйлчлүүлэгчийн бүртгэл, хяналтын онцлог, сул тал сөрөг нөлөөтэй бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан, залилан ба материаллаг алдаа бүхий тайлагналыг илрүүлэх, илрүүлэхгүй байх тохиолдол гарахыг бид үгүйсгэхгүй. Зайлсхийх боломжгүй ийм эрсдэлүүд аудитын ажлын практикт түгээмэл байдаг. Бид ийм алдаа гаргахгүй байхыг эрхэмлэн, тодруулах шаардлагатай болон материаллаг алдаатай мэдээлэл, бусад зүй бус илрүүлэлтийн хувьд холбогдох тайлбар тодруулгыг та бүхнээс тухай бүрд нь авна.

Санхүүгийн тайланд хийх аудитын гэрээт ажлын талаар Талуудын бусад үүрэг хариуцлага, ажлын хугацаа, үйлчилгээний хөлс болон бусад асуудлыг аудитын ажлын гэрээгээр зохицуулна.

Танай байгууллагын 2023.12.31-нээрх тасалбар оны жилийн санхүүгийн зэрэгцүүлсэн мэдээллийн аудитын гэрээт ажлын талаар дээр дурдсан зарчмын зүйлүүд нь энэ ажлын тухай таны ойлголттой нийцэж байвал энэхүү захидлын илүү нэг хувьд гарын үсгээ зурж бидэнд ирүүлнэ үү.

Та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа

ХҮНДЭТГЭСЭН:

“Шонхор үнэлгээ Аудит” ХХК-ийн

Захирал

ХҮЛЭЭН АВСАН:

“РЕМИКОН” ХХК -ийн

Гүйцэтгэх захирал



Д.Шийрэв

Э.Мөнхсайхан

Ремикон ХК

Компанийн засаглалын тухай мэдээлэл

Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй.

ТУЗ-н дарга: Р.Ганхуяг

ТУЗ-н хараат гишүүд: Х.Гантулга, Б.Батсайхан, Х.Хашчимэг, Ч.Мөнгөнсүх, Ц.Эрдэнэбаяр, Э.Мөнхсайхан

ТУЗ-н хараат бус гишүүд: Р.Ганхуяг, Д.Алтанхуяг, С.Баянмөнх

Гүйцэтгэх захирал: Э.Мөнхсайхан

Удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-н дэргэдэх хороодын мэдээлэл

1. Аудитын хороо

Чиг үүрэг: Компанийн нягтлан бодох бүртгэл, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа зэрэг асуудалд хяналт тавих, тодорхой асуудлуудыг шийдэх, ТУЗ-д мэдээлэл өгөх үүрэг бүхий байгууллага юм.

Хариуцлага: Аудитын хорооны гишүүд хорооноос гаргасан шийдвэр дүгнэлтийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Аудитын хорооны журамд заагдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

Гишүүдийн нэр:

Хорооны дарга С.Баянмөнх

Боловсрол: АНУ-ын "TEXAS WESLEYAN UNIVERSITY" сургуулийг Бизнесийн Удирдлагын Магистр, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ КТМС-ийг Бизнесийн Удирдлагын Магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Ажил эрхлэлт: АНУ-ын "RED HORSE REALTY" INC Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн шинжээч, "ORIENTAL GARDEN" INC Борлуулалтын туслах менежер, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ, КТМС-д Багш, 2012 оноос одоог хүртэл "BP MONGOLIA GROUP" ХХК-д Гүйцэтгэх захирлын албан тушаал эрхэлж байна.

Хорооны гишүүн Б.Батсайхан

Боловсрол: 2000 онд Япон улс "Хитоцубаши" их сургуулийг маркетинг өрсөлдөөний стратеги, суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2000-2002 онд Япон улсын "А.Т.Кеатау" компанид Маркетингийн зөвлөх, 2002-2003 онд Япон улсын "UNIQLO" компанид маркетингийн менежер, 2004-2005 онд "Эм Си Эс Групп"-д дэд ерөнхийлөгч, 2005-2007 онд "Гоёо" ХХК-д Гүйцэтгэх захирал, 2009 оноос одоог хүртэл "Монголын хөрөнгө оруулалтын сан"-ийн захирлаар ажиллаж байна.

Хорооны гишүүн Д.Алтанхуяг

Боловсрол: МУИС сургуулийг 1993 онд Электроник инженер мэргэжлээр, Зах зээлийн судалгааны хүрээлэн 1995 онд Гадаад худалдааны менежер, Удирдлагын академийг 2005 онд Удирдахуйн ухааны магистраар суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2005 оноос "Дорнод интернэшнл" компанид Гүйцэтгэх захирал, 2012 оны 01-р сараас өнөөг хүртэл "Аэр Зам" ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

2. Цалин урамшууллын хороо

Чиг үүрэг: Компанийн цалин урамшууллын системд хяналт тавих, компанийн удирдах албан тушаалтнуудын цалин урамшууллын системийг боловсруулах хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий байгууллага байна.

Хариуцлага: Цалин урамшууллын хорооны гишүүд хорооноос гаргасан шийдвэр дүгнэлтийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Цалин урамшууллын хорооны журамд заагдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

Гишүүдийн нэр:

Хорооны дарга Д.Алтанхуяг

Боловсрол: МУИС сургуулийг 1993 онд Электроник инженер мэргэжлээр, Зах зээлийн судалгааны хүрээлэн 1995 онд Гадаад худалдааны менежер, Удирдлагын академийг 2005 онд Удирдахуйн ухааны магистраар суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2005 оноос "Дорнод интернэшнл" компанид Гүйцэтгэх захирал, 2012 оны 01-р сараас өнөөг хүртэл "Аэр Зам" ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Хорооны гишүүн Ц.Эрдэнэбаяр

Боловсрол: 2001-2004 онд Улаанбаатар-Эрдэм судлал их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн.

Ажил эрхлэлт: 2000-2002 онд "Монос фарм" ХХК-д Экспидитор, 2004-2005 онд "Чоён Файнан"с ХЗХ-д Зээлийн эдийн засагчаар, 2006 оноос "Хера Фүүдс" ХХК-ийн Дэд захирлаар, 2007 оноос "Хера Холдинг"-ийн Тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Ремикон компанийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны даргаар ажиллаж байна.

Хорооны гишүүн С.Баянмөнх

Боловсрол: АНУ-ын "TEXAS WESLEYAN UNIVERSITY" сургуулийг Бизнесийн Удирдлагын Магистр, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ КТМС-ийг Бизнесийн Удирдлагын Магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Ажил эрхлэлт: АНУ-ын "RED HORSE REALTY" INC Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн шинжээч, "ORIENTAL GARDEN" INC Борлуулалтын туслах менежер, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ, КТМС-д Багш, 2012 оноос одоог хүртэл "BP MONGOLIA GROUP" ХХК-д Гүйцэтгэх захирлын албан тушаал эрхэлж байна.

3. Нэр дэвшүүлэх хороо

Чиг үүрэг: Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалд хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн иргэнийг шударгаар, хараат бусаар нэр дэвшүүлэх, шударгаар сонгогдох нөхцөлөөр хангах чиг үүрэгийг баримтална.

Хариуцлага: Нэр дэвшүүлэх хорооны гишүүд хорооноос гаргасан шийдвэр дүгнэлтийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Нэр дэвшүүлэх хорооны журамд заагдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

Гишүүдийн нэр:

Хорооны дарга Ц.Эрдэнэбаяр

Боловсрол: 2001-2004 онд Улаанбаатар-Эрдэм судлал их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн.

Ажил эрхлэлт: 2000-2002 онд "Монос фарм" ХХК-д Экспидитор, 2004-2005 онд "Чоён Файнан"с ХЗХ-д Зээлийн эдийн засагчаар, 2006 оноос "Хера Фүүдс" ХХК-ийн Дэд захирлаар, 2007 оноос "Хера Холдинг"-ийн Тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Ремикон компанийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны даргаар ажиллаж байна.

Хорооны гишүүн Д.Алтанхуяг

Боловсрол: МУИС сургуулийг 1993 онд Электроник инженер мэргэжлээр, Зах зээлийн судалгааны хүрээлэн 1995 онд Гадаад худалдааны менежер, Удирдлагын академийг 2005 онд Удирдахуйн ухааны магистраар суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2005 оноос "Дорнод интернэшнл" компанид Гүйцэтгэх захирал, 2012 оны 01-р сараас өнөөг хүртэл "Аэр Зам" ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Хорооны гишүүн Р.Ганхуяг

Боловсрол: Гадаад хэлний их сургуулийг 1994 онд Орос, Англи хэлний орчуулагч мэргэжлээр, Отгонтэнгэр их сургууль 2005 онд Эрхзүйч мэргэжлээр тус тус баклаверт суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2006 оноос "Их үйлсийн эрэлд" ХХкомпанид Гүйцэтгэх захирал, 2012 оноос өнөөг хүртэл "Их үйлсийн эрэлд" групп-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

ТУЗ хороод болон гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцэж дүгнэлт гаргаж байгаагүй. Жил бүр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Гүйцэтгэх удирдлага, ТУЗ болон Хороодын ажлын тайланг танилцуулдаг.